



## ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/35

Улаанбаатар хот

### Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15, 67 дугаар зүйлийн 67.5, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.2, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хотын стандартын баримт бичгийн хүртээмж хэрэглээ, ашиглах боломж зэргийг тодорхойлоход нийслэлийн нутгийн захиргааны байгууллага болон иргэн, аж ахуй нэгж байгууллагаас санал авах хуудасны загвар боловсруулж батлуулах үүрэг бүхий багийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Санал авах хуудасны загварыг холбогдох хууль тогтоомж болон үндэсний стандартад нийцүүлэн боловсруулж 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсэг (Д.Өлзийсайхан)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-т даалгасугай.

ДАРГА

С.ТӨМӨРДУЛАМ

1150500154

Газрын даргын 2022 оны 96 дугаар  
сарын 23-ны өдрийн 8/35 дугаар  
тушаалын хавсралт



## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Д.Өлзийсайхан  
(Байгаль орчны стандартын хэлтсийн даргын  
үүрэг гүйцэтгэгч)

Гишүүд: Б.Ариунзаяа  
(Худалдаа, үйлчилгээний стандартын  
хэлтсийн Ахлах мэргэжилтэн)

Г.Амартүвшин  
(Байгаль орчны стандартын хэлтсийн Ахлах  
мэргэжилтэн)

Л.Хүрэлтушаа  
(Стандартын хэрэгжилт, хяналтын хэлтсийн  
Хот тохижилтын стандарт хэрэгжүүлэлтийн  
мэргэжилтэн)

Б.Ундармаа  
(Хот нийтийн, аж ахуйн стандартын хэлтсийн  
Ногоон байгууламжийн стандарт хариуцсан  
мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Б.Биндэръяа  
(Хотын хөгжлийн стандартын хэлтсийн Хот  
төлөвлөлтийн стандарт хариуцсан  
мэргэжилтэн)